



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 670

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Геронтологийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 23 нэрийн, нийт 184,345,101.78 (нэг зуун наян дөрвөн сая гурван зуун дөчин таван мянга нэг зуун нэг төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 87,725,648.39 (наян долоон сая долоон зуун хорин таван мянга зургаан зуун дөчин найман төгрөг гучин есөн мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал Р.Хишигжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006870
34-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг
2023 оны 6 дугаар сарын 13-ны өдөр
670 дугаар тогтоолын хавсралт

ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох хугацаа (жил)	Цаашид шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
1	Түргэн тусламжийн авто машин улсын дугаар 6755 УБӨ, арлын дугаар MDHBBAN17Z0710056	2015.11.25	1	39,950,000.00	39,950,000.00	2	7,500,000.00	
2	Notebok	9/27/2017	1	1,699,900.00	1,699,900.00	3	500,000.00	500,000.00
3	ЭКГ 12 цаг холтер	8/11/2014	1	9,000,000.00	9,000,000.00	3	6,400,000.00	6,400,000.00
4	Зураасан код хэвлэгч	12/23/2015	2	950,738.68	1,901,477.36	3	475,369.34	950,738.68
5	Зураасан код уншигч	12/23/2015	2	654,700.29	1,309,400.58	3	327,350.15	654,700.29
6	Албан тасалгааны ус халаагч	12/26/2016	1	790,000.00	790,000.00	3	395,000.00	395,000.00
7	Шилэн хөргөгч	1/1/2008	1	226,000.00	226,000.00	3	113,000.00	113,000.00
8	Сейф	1/1/1992	1	18,100.00	18,100.00	5	9,050.00	9,050.00
9	Бичгийн ширээ AM-1200	10/31/2011	1	129,900.00	129,900.00	5	64,950.00	64,950.00
10	Шкаф эмнэлгийн	8/31/2011	1	340,000.00	340,000.00	5	170,000.00	170,000.00
11	Архивийн шүүгээ	10/31/2011	3	239,900.00	719,700.00	5	239,900.00	719,700.00
12	Бичгийн ширээ,	12/14/2012	4	198,550.00	794,200.00	5	99,275.00	397,100.00
13	Компьютер	12/23/2015	22	1,736,379.03	38,200,338.66	3	868,189.52	19,100,169.33
14	Сервэр компьютер	12/23/2015	1	19,344,970.31	19,344,970.31	3	9,672,485.16	9,672,485.16
15	Сервэр компьютер	12/23/2015	1	20,049,389.87	20,049,389.87	3	10,024,694.94	10,024,694.94
16	Камер	9/27/2017	1	1,383,000.00	1,383,000.00	3	891,000.00	891,000.00
17	Зурхний бичлэгийн аппарат 2000	6/30/2014	1	4,472,165.00	4,472,165.00	3	2,683,299.00	2,683,299.00
18	Зөөврийн эхо аппарат MySono	6/30/2014	1	42,564,810.00	42,564,810.00	3	25,538,886.00	25,538,886.00
19	Сандал / эргэдэг /	12/14/2012	8	125,300.00	1,002,400.00	5	62,650.00	501,200.00
20	Номын тавиур	12/14/2012	1	449,350.00	449,350.00	5	224,675.00	224,675.00
21	Ширээ	12/31/2020	5			5	150,000.00	750,000.00
22	Тумбочка	1/1/2021	8			5	50,000.00	400,000.00

23	Ус халаагч	1/2/2021	1		3	65,000.00	65,000.00
			55			66,524,774.09	80,225,648.39
	ДҮН			184,345,101.78 (нэг зуун наян дөрвөн сая гурван зуун дөчин таван мянга нэг зуун нэг төгрөг далан найман мөнгө)			(Наян долоон сая долоон зуун хорин таван мянган зургаан зуун дөчин найман төгрөг гучин есөн мөнгө)

